



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 106

Мандалговь

Хөрөнгө акталж, данснаас хасах, үнэ тогтоон нээлттэй дуудлага худалдаагаар худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1 дэх заалт, 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн 6.4.1 дэх заалт, 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 50,000,000 /тавин сая/ төгрөгийн балансын үнэтэй, 13,194,445 /арван гурван сая нэг зуун ерэн дөрвөн мянга дөрвөн зуун дөчин тав/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 21-83 ДУА улсын дугаартай Лексус 470 маркын автомашины доод үнийг 13,000,000 /арван гурван сая/ төгрөгөөр тогтоон нээлттэй дуудлага худалдаанд оруулах, 7,000,000 /долоон сая/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй 14-67 ДУА улсын дугаартай Зил-130 маркын автомашиныг акталж данснаас хасах, 00-37 ДУА улсын дугаартай Самосмол маркын автомашиныг акталж данснаас хасахыг тус тус зөвшөөрсүгэй.

Хоёр: Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар (С.Ууганбаяр)-г үүрэг болгосугай.


Гурав: Эд хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор акталж данснаас хассаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэж, тогтоолын биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхийг Эрдэнэдалай сумын засаг дарга (С.Мөнхбаатар)-д даалгасугай.

Дөрөв: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА

С.СҮХБААТАР





Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дүгээр сарын
23 өдрийн 106 тогтоолын нэгдүгээр хавсралт

Эрдэнэдалай сумын Засаг даргын тамгын газрын
актлах хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Хэмжих нэгж	тоо	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хур. элэгдэл	Үлдэх өртөг
1	Зил-130	1998	ш	1	7,000,000	7,000,000	7,000,000	0
2	Лексус-470	2006	ш	1	50,000,000	50,000,000	36,805,555	13,194,445
3	Самосмол	2005	ш	1	21,090,000	21,090,000	21,090,000	0
	Нийт дүн					78,090,000 /далан найман сая ерэн мянга /	64,895,555 /жаран дөрвөн сая найман зуун ерэн таван мянга таван зуун тавин тав/	13,194,445 /арван гурван сая нэг зуун ерэн дөрвөн мянга дөрвөн зуун дөчин тав/